

ШОГО ИШИЙ: МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ УЛАМ ХАТУУ БОЛГОХ ХЭРЭГТЭЙ

Олон Улсын Валютын Сан /ОУВС/-гийн Ази, Номхон далайн бүсийн төвийн захирал Шого Иший манай улсад айлчиллаа. Тэрбээр УИХ-ын дарга Д. Дэмбэрэлтэй уулзаж дэлхийн эдийн засгийн таагүй нөхцөл байдлаас сэрэмжлэхийг зөвлөсөн. ОУВС-гийн Ази, Номхон далайн бүсийн төв нь Японы Токиод байрладаг бөгөөд тэрбээр анх удаагаа Монгол оронд ирж буй. Тус төвийн захирлын албанд өнгөрсөн оны дөрөвдүгээр сард томилогдсон бөгөөд түүнтэй дэлхийн хийгээд манай улсын эдийн засгийн төлөв байдал, мөнгөний бодлогын талаар ярилцлаа.

- Монголын эдийн засгийн байдлыг ОУВС хэрхэн дүгнэж байна вэ?

- Монголын эдийн засаг улам бүр өргөжин тэлж, өсөн дэвшиж байгаа. Бидний зүгээс эдийн засгийг уян хатан байлгах зарим бодлогыг сайжруулсан гэж үзэж байна. Тодорхойбол, уян хатан ханшийн хэрэгжилт сайн болж, гадаад валютын нөөц түүхэндээ байгаагүйгээр өссөн. Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль өнгөрсөн онд батлагдсан. Энэ нь гадны хүчин зүйлээс хамгаалах сайн зэвсэг юм. Гэхдээ эдийн засаг халж байна, инфляцийн түвшин өсөх хандлагатай байна. Түүнчлэн банкны зээлийн хэмжээ 50-60 хувиар, хэрэглээний импорт 70-75 хувиар өссөн нь эдийн засагт халалт үүсэх шинж тэмдэг илрээд буйг харуулж байгаа юм. Тиймээс эрх баригчдын хувьд энэ халалтыг хэрхэн зохицуулах нь асуудал болоод байна.

- Дэлхийн эдийн засгийн байдал таагүй байгаа шүү дээ. Монголд гадны хүчин зүйл нөлөөлж байгаа бус уу?

- Европт Грекээс үүдэлтэй өр зээлийн хямрал болж байна. Харин АНУ-ын нэгдсэн төсөв маш том цоорхойтой болсон. Өөрөөр хэлбэл тэдний эдийн засгийн өсөлтийг хөдөлгөх хүч нь саарсан гэсэн үг. Тиймээс эдгээр улс эдийн засгаа тогтворжуулах том зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Газар хөдлөлт, цунамигийн улмаас Японы эдийн засаг ч хүнд цохилтонд орсон. Эдийн засгийг сэргээх арга хэмжээ одоо ч үргэлжилсээр байна. Тэгэхээр одоогийн дүр зургийг зургаан сарын өмнөхтэй харьцуулбал улам дордсон байгаа юм. Мөн хугацаанд “даунсайд риск” буюу зах зээлийн нөхцөл байдал муудахэрсдэлийн магадлал ч нэмэгдсэн. Тэгэхээр ийм дордсон нөхцөл байдал нь дэлхийн эдийн засгийн төлөв байдал мөн юм бол энэ нь Монгол болон Азийн бусад оронд хүнд цохилт болох юм. Танай улсын хувьд эдийн засаг халалттай, инфляцийн түвшин өндөр байгаа ч төрөөс зөв бодлого баримталбал үүнийг даван туулах бүрэн боломжтой. Гэхдээ АНУ, Европын байдал хурцадвал түүхий эдийн ханшид сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй. Монгол Улс түүхий эдээ экспортолдог орон. Энэ тохиолдолд Монголд таагүй нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэхгүй.

- Еврогийн бүсийн орнууд хямралд автахын хэрээр еврогийн ирээдүй бүрхэг болж байгаа гэдэгтэй санал нийлэх үү?

- Өр зээлийн хямралаас шалтгаалан зах зээлийн еврод итгэх итгэл суларсан нь үнэн. Тиймээс еврогийн эрэлт, еврогоор үнэлэгдэх хөрөнгө, барааны эрэлт буурах нь

тодорхой. Энэ нь швейцарь франк, Японы иенийн эрэлт нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйл болсон. Учир нь хөрөнгө оруулагч болон хүмүүс дээрх валютыг аюулгүй гэж үзэж байгаагаар тайлбарлаж болно. АНУ-ын хувьд төсөв нь нэлээд алдагдалтай, эдийн засгийн өсөлт нь саарсан, үл хөдлөх буюу орон сууцны зах зээл тун тааруу нөхцөл байдалтай байгаа. Тэгэхээр доллар, еврогоор үнэлэгддэг бараа бүтээгдэхүүн цөөрч, онгорхой зайг швейцарь франк, япон иенээр үнэлэгддэг бүтээгдэхүүн эзэлж эхэлж байгаа юм. Евро хэмээх валютын ирээдүйг бид бус еврогийн бүсийн эрх баригчдын бодлогоор тодорхойлох учиртай. Хэрэв тэд зөв бодлого хэрэгжүүлж чадвал еврод итгэх итгэл нэмэгдэж, эргэн тогтвортой байдалдаа орох болно.

- Монголын зарим эдийн засагч, бизнесмэн төрийн мөнгөний бодлогыг эсэргүүцэж байгаа. Зарим нь бүр гацаанд орчихсон гэж тодорхойлсон. Тэгэхээр ОУВС манай мөнгөний бодлогыг хатуу юу, эсвэл сул байна гэж үзэж байгаа юу?

- Бид Монголбанкны бодлогыг сайшааж байгаа. Инфляци 10-аас дээш хувьтай байгаа шүү дээ.

- Тэгэхээр ОУВС Монголбанкны бодлогыг дэмжиж байгаа гэж ойлгож болох нь ээ?

- Тэгж ойлгож болно. Харин ч Монголбанк мөнгөний бодлогоо сул байлгаад байгаа юм. Хатууруулах хэрэгтэй.

- Хэр хатуу байх хэрэгтэй вэ. Өөрөөр хэлбэл бодлогын хүү хэд байх ёстой юм бэ?

- Би яг энэ талаар сайн хэлж чадахгүй. Үндсэндээ эдийн засаг халалттайгаас гадна инфляци өндөр байна. Бид яагаад инфляцийг чухалчилж авч үзээд байна гэхээр хэд хэдэн шалтгаан бий. Үүний нэг нь нийгмийн дундаас доогуур болон эмзэг бүлгийнхэнд инфляци хамгийн хүнд тусдаг. Цалин, орлогын хэмжээ тодорхой хэмжээнд байхад өргөн хэрэглээний барааны үнэ тогтмол өссөөр байгаа шүү дээ. Тэгэхээр тэдний худалдан авах чадвар суларсаар байгаа юм. Түүнчлэн инфляци бизнесийн салбарт хүнд тусч байгаа нь үнэн. Хэрэв бид хүнсний бүтээгдэхүүний үнийг хэрэглээний сагснаас хасч тооцвол инфляци 15-20 хувь байна. Ингэхээр дээрх инфляци бодлогын хүүний хэмжээнээс илүү байгаа юм. Тэгэхээр мөнгө үнэгүйдээд эхэлж байгаа гэж ойлгож болно.

- Иргэн бүрт сар тутам 21 мянган төгрөг олгож байгаа шүү дээ. Үүнийг ОУВС-гийнхан хэрхэн үзэж байгаа нь сонирхолтой санагдлаа?

- Бид үүнийг буруу зөв гэж шүүх эрх байхгүй. Гэхдээ үүний хүрээг хумих нь зүйтэй болов уу. Ялангуяа, дээрх мөнгийг дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулахыг дэмжиж байгаа. Бага орлоготой иргэдэд энэ мөнгө маш том тус болж байгаа ч бүхэл нийгмээр нь авч үзвэл 21 мянган төгрөгийн ерөнхий зарцуулалт нь тодорхойгүй. Тиймээс юунд зарцуулах нь тодорхой, үр дүн нь мөн тодорхой болох тийм зүйлд зарцуулахыг бид дэмжиж байгаа гэсэн үг. Энэ мөнгө бага орлоготой

иргэдэд хэрэгтэй байгаа шигээ өндөр орлоготой иргэдэд хэрэгцээтэй байгаа нь үнэнд үл нийцнэ.

- Сүүлчийн асуултыг танд үлдээе.

- Монголд анх удаа ирлээ. Үнэхээр сайхан орон юм. ОУВС-гийн Монгол дахь одоогийн суурин төлөөлөгч удахгүй Вашингтоныг зорих юм. Гэхдээ түүний оронд ажиллах суурин төлөөлөгч томилогдохгүй. Бид Токиогоос Монгол дахь салбараа удирдах болно. Цаашид улам гүнзгий хамтарч ажиллана гэж найдаж байна.

А. АРИУНБОЛД